

ГАРЧИГ

Д.Д	НЭР	ХУУДАСНЫ ДУГААР
1	Төслийн товч танилцуулга	3
2	Уурхайн технологийн хэсэг	8
3	Эцсийн бүтээгдэхүүний агуулах ба дахин ачилт	10
4	Дэд бүтэц удирдлага зохион байгуулалт	10
5	Байгаль орчны нөхөн сэргээлт	10
6	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	11
7	Байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөө	15
8	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	19
9	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
10	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	20
11	Түүх соёлын өв хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
12	Уул уурхайн төслийн БОМТ-ийн хяналтын хуудас	25

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Хараа-3” элсний орд нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт УБТЗ-ын Салхит өртөөнөөс урагш шулуун зайгаар 2.2 км-т, Хараа голын баруун эрэгт оршино. (Хавсралт зураг №1)

АМГТХЭГ-ын ГУУКА-аас “Дархан Молор Эрдэнэ” ХХК-д 2007 оны 01 дүгээр сарын 29-нд олгосон MV-001824 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хараа-3” нэртэй талбай нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн 1:100000 масштабтай байр зүйн зургийн М-48-104 нэрлэвэртэй хавтгайд оршино. Талбайн тусгай зөвшөөрлийн дугаар, байршлын солбицол, талбайн хэмжээг хүснэгт №1-1-д үзүүлэв.

Хүснэгт №1-1

Талбайн нэр	Тусгай зөвшөөрлийн лийн	Талбайн булангийн эргэлтийн цэгийн солбилцол (WGS-84 эллипсоидод)		Тэгш өнцгийн солбицол (UTM тусгалд)		Талбайн хэмжээ (га)	Тусгай зөвшөөрөл олгосон огноо
		Өргөрөг	Уртраг	X	Y		
араа-3 элсний орд	MV-001824	1. 105° 51' 50.04"	49° 10' 56.29"	5448081.0440	562956.5480	15.92	2007/01/29
		2. 105° 51' 32.72"	49° 10' 42.11"	5447639.1799	562610.9120		
		3. 105° 51' 32.79"	49° 10' 42.69"	5447657.1062	562612.1258		
		4. 105° 51' 32.78"	49° 10' 43.35"	5447677.4845	562611.6921		
		5. 105° 51' 32.67"	49° 10' 44.17"	5447702.7806	562609.1779		
		6. 105° 51' 32.52"	49° 10' 44.81"	5447722.5092	562605.9170		
		7. 105° 51' 32.19"	49° 10' 45.69"	5447749.6075	562598.9282		
		8. 105° 51' 31.82"	49° 10' 46.44"	5447772.6823	562591.1752		
		9. 105° 51' 31.29"	49° 10' 47.28"	5447798.4996	562580.1517		
		10. 105° 51' 30.79"	49° 10' 47.90"	5447817.5302	562569.8127		
		11. 105° 51' 30.12"	49° 10' 48.59"	5447838.6834	562556.0078		
		12. 105° 51' 29.42"	49° 10' 49.21"	5447857.6681	562541.6202		
		13. 105° 51' 28.05"	49° 10' 50.29"	5447890.7039	562513.5086		
		14. 105° 51' 27.02"	49° 10' 51.01"	5447912.7011	562492.4060		
		15. 105° 51' 28.48"	49° 10' 51.91"	5447940.8277	562521.6464		
		16. 105° 51' 29.73"	49° 10' 52.82"	5447969.2150	562546.6319		
		17. 105° 51' 30.88"	49° 10' 53.84"	5448000.9763	562569.5544		
		18. 105° 51' 31.81"	49° 10' 54.89"	5448033.6135	562588.0126		
		19. 105° 51' 32.57"	49° 10' 55.93"	5448065.9030	562603.0328		
		20. 105° 51' 33.12"	49° 10' 56.95"	5448097.5267	562613.8088		
		21. 105° 51' 33.45"	49° 10' 58.04"	5448131.2614	562620.1069		
		22. 105° 51' 33.58"	49° 10' 59.17"	5448166.1853	562622.3423		
		23. 105° 51' 33.43"	49° 11' 01.19"	5448228.5279	562618.5979		
		24. 105° 51' 33.30"	49° 11' 01.91"	5448250.7314	562615.7141		
		25. 105° 51' 54.19"	49° 11' 01.91"	5448255.5473	563038.5725		

1.2 “ХАРАА-3” ЭЛСНИЙ ОРДЫН ГЕОЛОГИЙН ТОГТОО

1.2.1 Ордын ерөнхий мэдээлэл

Уул зүйн байрлалаар ордын район нь Хэнтийн уулархаг мужийн баруун урд хэсэгт хамаарагдана.

Районы газрын гадарга нь дунд зэргийн өндөртэй уулс хоорондын жижиг толгодлог хөндий, зарим газартаа доворхог тал газрын хэлбэртэй байна.

Ордын талбайн гадаргуугийн рельеф нь тэгшивтэр, голын урсгалын дагуу урдаас, хойш чиглэсэн бага зэрэг налуу гадаргуу үүсгэсэн байдаг. Ус зүйн хувьд Төв Азийн гадагшаа урсгалтай голын ай савд багтана. Усан сүлжээний хувьд ордын районд хамгийн том гол нь өмнөөс хойш урсаж байгаа Хараа гол бөгөөд элсний Хараа-3 орд энэ голын хөндийд оршино.

Хараа голын хөндий нь нилээд өргөн 3.0-7.0 км хүрдэг ба хөндийн хамгийн өндөр цэг нь 742 м байна.

Ордын талбайн хүрээнд ямар нэг суурин газар, барилга байгууламж, тариа ногооны талбай байхгүй. Тус орд нь манай аж үйлдвэрийн төвийн бүсэд байрладаг, дэд бүтэц сайн хөгжсөн дэвсгэр нутагт оршдог.

Цаг агаар: Орд нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших тул уур амьсгалын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай ба жилийн дундаж температурын хэлбэлзэл ихтэй байна. Жилийн дундаж температур +10.2 хэм, хамгийн хүйтэндээ 1-р сарын зарим үед -35 хэм хүрэх ба их халуун нь 7-р сард +35 хэм байдаг.

Эдийн засгийн байдал: Эдийн засгийн хувьд тус район нь хот суурин хөгжсөн, зам харилцаа сайтай, Төвийн эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбогдсон.

Ордтой хамгийн ойр орших суурин газрууд нь Дархан хот, Сайхан, Хонгор сум, Салхит өртөө юм.

Эдгээрээс хамгийн томоохон нь Монгол улсын аж үйлдвэрийн төвүүдийн нэг Дархан хот бөгөөд энд дулааны цахилгаан станц, цементийн үйлдвэр, царууц тоосгоны үйлдвэр, эрдэс хөвөнгийн болон бусад барилгын материалын үйлдвэрүүд бий.

1.2.2 Ордын геологийн тогтоц

Геологийн тогтоцны хувьд Хараа элсний орд нь Хараа голын хөндийн дэнжид тархсан дунд плестоцены настай аллювийн гаралтай нэг төрлийн хурдаснаас тогтоно. Ордын элс нь Хараа голын хөндийн I дэнжид голын урсгалын дагуу урдаас хойш сунаж тогтсон ба ордын хайгуул хийсэн хэсгийн урт нь 470 м, өргөн нь 15-24 м дунджаар 16.0 м байна.

Ордыг бүрдүүлж байгаа хурдас нь бүхэлдээ голын хөндийн I дэнжийн аллювийн хурдас болох элснээс тогтох бөгөөд эдгээр нь ерөнхийдээ нэг төрлийн жигд найрлагатай, саарал, шаравтар саарал өнгөтэй, том ширхэгтэй байна.

Ордын хайгуул хийсэн хэсэг дэх элсний давхарга дотор өөр төрлийн болон онцгой ялгарах чулуулгийн үе судлууд байхгүй байна.

Ордын элсэн дэх том ширхэгт хольц буюу 5 мм-ээс том хэмжээтэй хэсэг нь 5.3-12.1%-д хэлбэлзэх ба ордын хэмжээнд дунджаар 8.8 % байна.

Ордын элс нь нэг төрлийн, тогтвортой кварц-хээрийн жоншны найрлагатай, том хэмхдэслэг хольц нь зонхилж метаморфжсон элсэн чулуу, боржин, риолит, дацитийн төрлийн чулуулаг байна.

Элс нь шаварлаг ба тоосорхог хэсэг багатай, органик хольцгүй байна.

1.3. Ордын геологийн судлагдсан түүх

Дархан-Уул, Сэлэнгэ аймгууд, Орхон, Хараа голуудын бэлчир нутгийн геологийн судалгаа үндсэндээ ЗХУ-ын Шинжлэх ухааны академи, БНМАУ-ын Шинжлэх ухааны хорооны хамтарсан экспедицүүд 1950-аад онд байгуулагдан судалгаа явуулснаар эхлэсэн гэж үздэг.

2011 онд "Дархан Молор эрдэнэ" ХХК нь Хараа-3 элсний ордод хайгуулын ажил хийж, элс-хайрганы хольцын бодитой (В) нөөцийг 368083.7 куб.м, үүнээс 32576.9 м³ нь хайрга, 335506.8 м³ нь элс гэж тогтоосон байна.

1.4. Ордын геологийн тогтоц

Геологийн тогтцын хувьд Хараа элсний орд нь Хараа голын хөндийн дэнжид тархсан дунд плестоцены настай аллювийн гаралтай нэг төрлийн хурдаснаас тогтоно. Ордын элс нь Хараа голын хөндийн I дэнжид голын урсгалын дагуу урдас хойш сунаж тогтсон ба ордын хайгуул хийсэн хэсгийн урт нь 470 м, өргөн нь 15-24 м дунджаар 16.0 м байна. Ордыг бүрдүүлж байгаа хурдас нь бүхэлдээ голын хөндийн I дэнжийн аллювийн хурдас болох элснээс тогтох бөгөөд эдгээр нь ерөнхийдээ нэг төрлийн жигд найрлагатай, саарал, шаравтар саарал өнгөтэй, том ширхэгтэй байна.

Ордын хайгуул хийсэн хэсэг дэх элсний давхарга дотор өөр төрлийн болон онцгой ялгарах чулуулгийн үе судлууд байхгүй байна.

Ордын элсэн дэх том ширхэгт хольц буюу 5 мм-ээс том хэмжээтэй хэсэг нь 5.3-12.1%-д хэлбэлзэх ба ордын хэмжээнд дунджаар 8.8 % байна.

Ордын элс нь нэг төрлийн, тогтвортой кварц-хээрийн жоншны найрлагатай, том хэмхдэслэг хольц нь зонхилж метаморфжсон элсэн чулуу, боржин, риолит, дацитийн төрлийн чулуулаг байна.

Элс нь шаварлаг ба тоосорхог хэсэг багатай, органик хольцгүй байна.

1.5. Ордын гидрогеологийн нөхцөл

Хараа-3 элсний орд нь 1971 онд хайгуул хийсэн Сайханы, 1981 онд хайгуул хийсэн Салхитын элсний, 2007 онд хайгуул хийсэн Хараа-2 элс-хайрганы хольцын ордуудтай нэг хөндийд оршдог тул гидрогеологийн нөхцөлийн хувьд төстэй юм.

Сайханы элсний ордод 1981 онд хийсэн судалгаагаар Хараа голын дэнжид голоос тэжээгдэл авдаг газрын доорх усны давхарга ихэнхдээ 3 м ба түүнээс доош гүнээс илэрнэ гэж тогтоожээ.

Ус агуулагч үе давхаргын литологийн бүрэлдэхүүний онцлогоос шалтгаалан энэ хурдас дахь цооногуудад усны ундарга харилцан адилгүй, хоорондоо нилээд их ялгаатай байна.

Хараа голын баруун хөндийн татмын захын хэсэгт 1962 онд өрөмдсөн гидрогеологийн 7-р цооногт 39.5-66.0 м гүнд сийрэг сул тогтоцтой жижиг бул чулуу, хайрга, хайрганцрын үе илэрсэн бөгөөд энэ давхаргад туршилтын шавхалт явуулахад цооног дахь усны ундарга 11.6 л/сек, усны төвшний бууралт 1.45 м байжээ.

2007 онд геологич Р.Баттөмөр, Д.Дорж нарын Хараа голын хөндийн татамын хэсэгт хийсэн газрын доорх усны ашиглалтын хайгуулын ажлаар усны нөөцийг үйлдвэрлэлийн А+В зэргээр 490л/сек буюу 42336.0 м³/хоног гэж тогтоожээ.

Эндээс Хараа элсний ордод олборлолт хийх үеийн техникийн ба ахуйн хэрэглээний усыг энэ дүүргээс хангах бүрэн боломжтой байна.

1.6. Судлагдсан талбайн үнэлгээ

Хайгуул хийгдсэн талбайд элсний ордоос өөр төрлийн ашигт малтмалын орд, илрэл байх хэтийн төлөвгүй юм.

Орд нь Хараа голын хөндийд орших боловч голын гольдролоос хол дэнж дээр орших тул голын усанд үзүүлэх сөрөг нөлөөгүй.

Ордын талбайд барилга байгууламж, мод сөөг, айл байхгүй тул олборлолт хийхэд ямар нэг саад байхгүй юм.

Орд нь элс хайрганы ордын нөөцийн ангиллын зааврын дагуу 1-р бүлэгт хамаарна.

1.7. Ордын элс хайрганы холимгийн чанарын тодорхойлолт

Элс, хайрганы техникийн шаардлага:(MNS-392-98, MNS-2803-2004)

а. Элс-хайргыг хүнд болон элсэн дүүргэгчтэй сүвэрхэг бетон эдлэхүүн, замын далан хийхэд голчлон ашиглана.

Элс: / MNS-392-98/

1. Элсэнд 10 мм-ээс том ширхэгтэй чулуулаг байж болохгүй бөгөөд 5-10 мм хэмжээтэй чулуулаг жингийн 5 %-оос хэтрэхгүй байвал зохино.

2. Элсэнд агуулагдах 0.1 мм-ээс жижиг ширхэг болон тоос, шаварлаг хольц нь доорх хүснэгтэд зааснаас ихгүй байна.

Хүснэгт №1-2

Элсний төрөл	< 0,14 мм хэсэг, ,%	Тоос, шаварлаг хольц, %
Байгалийн элс	10	3
Байгалийн ширхэглэлээр ангилсан элс:		
Том ширхэгтэй	-	2
Жижиг ширхэгтэй	10	2
Байгалийн баяжуулсан элс	5	2
Буталж гаргаж авсан элс	10	3

Элсийг ширхгийн бүрэлдэхүүнээр нь том, дунд зэрэг, нарийн, маш нарийн ширхэгтэй гэж ангилах ба 5 мм-ээс том ширхэгтэй хэсгийг ялгасны дараах ширхгийн модуль, 0.63 мм-ийн шигшүүр дээрх бүрэн үлдэгдэл нь доорх хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

Хүснэгт №1-3

Элсний ангилал	Ширхгийн модуль	0.63мм-ийн шигшүүр дээрх бүрэн үлдэгдэл, %
----------------	-----------------	--

Том ширхэгтэй	2.5-аас их	45-аас их
Дунд зэргийн ширхэгтэй	2.0-2.5	30-45
Нарийн ширхэгтэй	1.5-2.0	10-30
Маш нарийн ширхэгтэй	1.5-аас бага	10 хүртэл

2. Гоос, шаварлаг хольц дахь шаврын хэмжээ байгалийн болон буталж гаргасан элсэнд жингийн 0.5%-иас, ширхэглэлээр ангилсан буюу баяжуулсан элсэнд жингийн 0.25%-иас ихгүй байна.

3. Элсэнд хатуурч бөөгнөрсөн бүхэл наанги шавар болон гаднын ямарч бохирдол байж болохгүй.

Ордын ашигт малтмалын чанарын үнэлгээ

Ордын элсний чанарын үнэлгээг 7 дээжийн физик-механикийн бүрэн ба ширхгийн бүрэлдэхүүний шинжилгээ, 2 дээжийн химийн, 2 дээжийн эрдсийн, 2 дээжийн урвалжих чадварын, 2 дээжийн цацрагийн, 1 дээжийн лаборатори-технологийн ба бетоны найрлага тогтоох туршилтын үр дүнгүүдийг үндэслэн хийжээ.

Бүх хайгуулын малталтуудаас авсан дээжүүдийг 5, 2.5, 1.25, 0.63, 0.315, 0.14, < 0.14 мм-ийн тороор шигшүүлж, ширхгийн бүрэлдэхүүнийг тодорхойлуулсан байна.

Энэ шинжилгээгээр Хараа ордын элсэн дэх > 5 мм-ийн хэмжээтэй хэсэг буюу хайрган хольцын агуулга 5.3-12.1.%-д хэлбэлзэх ба ордын хэмжээнд дунджаар 8.7 % байна. Элсэн дэх хайрган хольц буюу 5-10 мм хэмжээтэй хэсгийн агуулга жингийн 5%-оос хэтрэх тохиолдолд хортой хольцод хамаарах (MNS-392-98-ийн шаардлагаар) ба энэ нь уг ордын элсийг ашиглах тохиолдолд хайрган хольцыг шигшиж зайлуулах шаардлагатайг харуулж байна.

1.8. Ордын нөөц ашиглалтад бэлтгэгдсэн байдал

Геологийн тогтцын шинж чанар, ашигт малтмалын нөөцийн хэмжээгээрээ Хараа-3 элсний орд нь “Элс-хайрганы ордод нөөцийн ангилал хэрэглэх заавар”-ын дагуу 1-р бүлгийн ордод хамаарах ба ийм орд ашигт малтмалын зузаан ба чанараар тогтвортой, хэмжээний хувьд том, дунд зэргийн аллювийн гаралтай, давхарга маягийн орд байна.

Хараа ордын элсний нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

Хүснэгт №1-4

№ д/д	Нөөцийн блоккийн дугаар ба нөөцийн зэрэг	Блоккийн талбай, кв.м.	Хуулах хөрсний дундаж зузаан, м	Ашигт малтмалын дундаж зузаан, м	Хуулах хөрсний эзлэхүүн м ³	Ашигт малтмалын нөөц				Хуулах хөрсний эзлэхүүнийг ашигт малтмалд харьцуулсан харьцаа м ³ /м ³
						Нийт, м ³	Хайрган хольцын агуулга, %	Хайрган хольцын эзлэхүүн, м ³	Цэвэр элсний нөөц, м ³	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	В-I	40120.4	0.4	4.6	16048.2	184553.8	9.0	16609.8	167944.0	0.095
2	В- II	39897.8	0.4	4.6	15959.1	183529.9	8.7	15967.1	167562.8	0.095
Бүгд: Бодитой (В) нөөц		80018.2	0.4	4.6	32007.3	368083.7		32576.9	335506.8	0.095

ХОЁР. УУРХАЙН ТЕХНОЛОГИЙН ХЭСЭГ

2.1. Ордын уул-техникийн нөхцөл

Хараа-3 элсний ордын талбай нь бараг тэгш гадаргуутай бөгөөд голын урсгалынхаа дагуу урдаас хойш энгийн нүдээр үл ажиглагдам налуутай.

Хараа-3 элсний ордыг ил уурхайн аргаар олборлоход тохиромжтой юм.

Ордод хуулах хөрсний зузаан дунджаар 0.4 м ба ашигт малтмалын зузаан нь 4.4 - 4.7 м -т хэлбэлзэх ба ордын хэмжээнд дунджаар 4.6 м байна.

Орд нь үйлдвэрлэлийн чиглэлээр олборлолт хийхэд бүрэн бэлтгэгдсэн, олборлолтын тоног төхөөрөмж, хүнд механизм чөлөөтэй нэвтрэх боломжтой.

Ордоос хойш 8 км орчим зайд Улаанбаатар-Дархан-Сүхбаатарын хатуу хучилттай авто зам байдаг ба Сүхбаатар-Дархан-Улаанбаатар-Замын-Үүдийн төмөр зам ордын дэргэдэх Салхит өртөөг дайран өнгөрдөг.

Салхит өртөөнөөс Хараа-3 элсний орд хүртэл 1200 метр орчим урт төмөр замыг "Дархан молор эрдэнэ" ХХК өөрийн хөрөнгөөр тавьсан учир элсийг хэрэглэгч хүртэл авто болон төмөр замаар тээвэрлэнэ.

Олборлолт хийх явцад шаардагдах техникийн хэрэглээний усыг уурхайн шүүрэлтийн уснаас авч ашиглах боломжтой.

2.2. Ил уурхайн талбайн техникийн хил хязгаар

"Хараа-3" элсний ордын MV-001824 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий 15.92 га газрын 8.27 га-д хийгдсэн хайгуулын ажлаар 2 блокод бодит нөөцийг тооцжээ.

Эндээс ЭБМЗ-ийн 2017 оны 05-р сарын 04-ний хуралдааны ХХ-06-02 дугаартай дүгнэлт, АМГТГ-ын даргын 2017 оны 5 сарын 31-ны н/37 тоот тушаалаар ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдсэн бодитой (В) 368083.7м³ нөөцийн хүрээнд техник эдийн засгийн үндэслэлийг хийж, 2018 оны уулын ажлыг төлөвлөгөөг боловсрууллаа.

2.3. Ил уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Ашигт малтмалыг газрын хэвлийгээс олборлон гаргахад техник, технологийн хувьд нөөцийг бүрэн хэмжээгээр олборлоход тодорхой хэмжээний хаягдал гардаг.

Нөгөө талаас ашигт малтмалын тогтоц, тухайн ордын уул геологи, уул техникийн нөхцөл, ашиглалтын технологи зэргээс шалтгаалж бохирдолт үүсдэг.

Иймд геологийн нөөцийн хэмжээ ашиглалтын явцад ямар нэг хэмжээгээр өөрчлөгддөг бөгөөд энэ нь ашиглалтын үеийн хаягдал, бохирдолттой холбоотой байна.

**Хараа-3 элсний ордын ашиглалтын хаягдал, бохирдолтын тооцоо,
үйлдвэрийн магадласан нөөцийн хүснэгт**

Хүснэгт №2-1

Геологийн нөөц					Ашиглалтын хаягдал		Бохирдолт		Үйлдвэрийн магадласан нөөц				
Блокийн дугаар	Ордын нөөцийн блоктын хилээр хөрс хуулах талбай, м ²	Хөрсний зузаан, м	Хөрсний эзлэхүүн, м ³	Геологийн нийт нөөц, м ³					Уурхайн хилээр нөөцийн блоктын хөрс хуулах талбай, м ²	Хөрсний зузаан, м	Хөрсний эзлэхүүн, м ³	Магадлагдсан үйлдвэрлэлийн нөөц,	
					зэрэг	элс, м ³							
В-I	40120.4	0.4	16048.2	184553.8	5.27	9725.98	1.47	2712.94	40824.35	0.5	20412.2	В'-1	177540.76
В-II	39897.8	0.4	15959.1	183529.9	5.27	9672.02	1.47	2697.89	41869.32	0.5	20934.7	В'-2	176555.77
Нийт	80018.2		32007.3	368083.7	5.27	19398.0	1.47	5410.83	82693.67	0.5	41346.9	В'	354096.53

2.4. УУРХАЙН ХУЧИН ЧАДАЛ БА АЖИЛЛАХ ГОРИМ, АЖИЛЛАХ ХУГАЦАА

2.4.1. Уурхайн жилийн хүчин чадал

Уурхайн хүчин чадлыг “Дархан Молор-Эрдэнэ” ХХК-ийн техникийн даалгаврын дагуу жилд 20.0 мян.м³ элс олборлохоор 2023 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгалаа.

2.4.2. Үйлдвэрлэлийн ажиллах горим

Үйлдвэрлэлийн ажиллах горим, ашиглалтын хугацааг уурхайн жилийн хүчин чадлаас хамааруулан тооцоолов. Ил уурхай нь улирлын чанартай дулааны улиралд (6-р сарын 05-наас 11-р сарын 05 хүртэл) 6 сарын хугацаанд хоногт 1 ээлж, ээлжид 8 цагаар ажиллана.

Ажилчдын баяр ёслолын болон амралтын үеийн амрах хугацааг МУ-ын хөдөлмөрийн хуулийн дагуу уурхайг эзэмшигч компанийн захирлын тушаалаар зохицуулна.

Жилд ажиллах хуанлийн хоног –	153
Засварт зогсох хоног –	14
Амралт, баяр ёслолын хоног –	25
Цаг агаарын болон болзошгүй саатлын хоног –	14
Жинхэнэ ажиллах хоног –	100
Хоногт ажиллах ээлж –	1
Ээлжийн үргэлжлэх хугацаа –	8
Уурхайн ээлжийн тооцооны бүтээл –	200 м ³ /ээлж


Уурхайн ээлжийн тооцооны бүтээл: 200 м³/ээлж болон сийрэгжилт $K_c = 1.2$ -ыг тооцвол 240 м³/ээлж, 374.4 тн/ээлж болно.

2.5. АШИГЛАЛТЫН СИСТЕМ

2.5.1. Ашиглалтын системийн сонголт

Орд газарт ил аргаар ашиглалт явуулахад уул-геологи, уул-техникийн хүндрэл гарахгүй.

Ордыг ашиглах хэтийн төлөв, уул-техникийн нөхцөл болон, захиалагчийн техникийн даалгаврыг үндэслэн тээвэртэй ашиглалтын систем сонгон авлаа. Ордын хөрс нь 0.4 м зузаан шимт хөрс юм. Шимт хөрсийг экскаватороор хуулан уурхайн хилээс гадагш хилийн дагуу түр овоолгод хадгална. Элсийг уурхайгаас экскаватороор авч мөргөцөг, доголын дээр овоолго байгуулан усгүйжүүлж экскаватор, шууд утгуурт дугуйт ачигч, автосамосвалын хослол хэрэглэн төмөр замын дэргэд байх ангилах шигшүүр төхөөрөмж хүртэл 0.5 км хүртэл зайд тээвэрлэнэ.



ГУРАВ. Эцсийн бүтээгдэхүүний агуулах ба дахин ачилт

Уурхайгаас олборлосон элс хайргыг боловсруулах үйлдвэрт хэрэгцээт ширхэглэлээр ангилан ялгаж ТЗ-ын Салхит өртөөнөөс салаалж байгуулсан төмөр замаар тээвэрлэн борлуулалт хийнэ.

Борлуулах бэлэн бүтээгдэхүүн болох элсийг салаа төмөр замын дэргэдэх ил талбайд түр овоолон хадгалах ба шууд утгуурт ачигчаар вагонд ачна.

ДӨРӨВ. ДЭД БҮТЭЦ БА УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

"Хараа-3" элсний îäòд 18 æëë үйлдвэрëýë үäòòëäò òòë ¿éëäýðëéí áíëí туслах объектууд байх øäàäëäãäòäé äà ажиллагсдын хөдөлгөрлөх нөхцлийг дээд зэргээр хангах зохион байгуулалтын бүхий л арга хэмжээг авна.

Уг ордын нөөц тогтоогдсон талбайн ойр орчим нь äýä á¿òýò ñäéí ð°äæñ°í УБ ТЗ-ын Салхит өртөөний дэргэд байдаг. Èéä элс олборлож ангилан ялгах ¿éë äæëëäãäà üäòòëäòää íýí ðààäàé үäëéí çàñäëéí ð°äë°ðñ°í á¿ñýä òàìääðà.

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТ

5.1. Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл

Уг төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой баримт бичиг юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, байгалийн нөөц баялагийг зүй зохистой ашиглах боломж бүрдэхээс гадна төслийн хэрэгжих чадварыг дээшлүүлж, эдийн засгийн үр ашиг нэмэгддэг.

Энэхүү төлөвлөгөөгөөр Дархан –Уул аймгийн Хонгор сумын нутаг дахь Хараа-3 элсний ордын элс олборлох үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй болон голлох сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно. Уг төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн хураангуй бөгөөд хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулж тусгай хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллавал илүү үр дүнтэй байх болно. Мөн төлөвлөгөөг орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнтэй уялдуулж, жил бүр хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай.

"Хараа-3" ордыг ашиглах хугацаанд нийт 2.3 мян.м³ хөрс хуулж, 20.0 мян.м³ элс олборлох бөгөөд үүний улмаас уурхайн орчны экологид тодорхой хэмжээний сөрөг нөлөөлөл бий болно.

Уурхайн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд дараах сөрөг нөлөөлөл бий болно гэж үзэж байна. Үүнд:

- Уурхайн хөрс хуулалт, элс олборлолтын үйл ажиллагааны улмаас орчны тоосжилт нэмэгдэх,
- Уурхайн ойр орчимд хөрсний эвдрэл, гэмтэл үүсэх,
Ордыг ашиглах үйл ажиллагааны улмаас үүсэх эвдрэл, үүнд:

Байгаль хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдуулан малталтын хил хязгаарыг тэмдэгжүүлэх ажил гүйцэтгэж, ашиглалт дууссан хэсэгт нөхөн сэргээлт хийхдээ:

"Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага" MNS-5918:2008, "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага" MNS-5917:2008, "Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс

хуулалт, хадгалалт" MNS-5916:2008 мөн MNS 5915:2008, MNS 4920:2000 стандартуудын шаардлагыг хангахуйц төвшинд хийж гүйцэтгэнэ.

Үйлдвэрлэл явуулж байгаа талбайгаас гадна хэрэгцээгүй зам харгуй гаргахгүй, гол замыг олон салаалуулахгүй байх арга хэмжээ авч, автомашин, механизмын засвар үйлчилгээ, гарсан хог хаягдал, асгарсан тос шатахууныг тусгай нүх, саванд хийж, газар усыг бохирдуулахгүй байх арга авч ажиллана.

Цаг агаарын хуурайшилтын үед гал түймрээс урьдчилан сэргийлэх үүднээс ил гал, түүдэг асаахыг хориглох, байгалийн түймрээс сэргийлэх санамж, зааврыг тухай бүр өгч ажиллуулж байх, ан амьтан агнах, ой модыг сүйтгэх, хэрэгцээгүй огтлох, байгалийн бусад баялгийг хууль бусаар ашиглах зэргийг хориглож, сурталчилан таниулах ажлыг тогтмол зохион байгуулах, байгаль хамгаалах асуудлаар сум, орон нутгийн засаг захиргаа, холбогдох мэргэжилтнүүдтэй нягт холбоотой хамтран ажиллана.

5.2 . Техникийн нөхөн сэргээлт

Хөрсний гадаад овоолгыг тэгшлэх, хэлбэржүүлэх, хажууг налуулах болон шимт хөрсөөр бүрэх, суваг шуудуу татах зэрэг ажлууд болно.

Уурхайн ойр орчмын зам, талбайд үүсэх хөрсний эвдрэл, гэмтлийг тэгшлэх, түрэх зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.

Техникийн нөхөн сэргээлтийн чиглэлээр тусгайлан хэрэгжүүлэх ажил маш бага байх бөгөөд ихэнх ажил ашиглалтын үйл явцад хэрэгжинэ. Техникийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд цөөрмийн хажууг хэлбэржүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

Сүүлийн жилүүдэд хотод суурьших хүн амын тоо өсч, хотжилт явагдаж барилга, орон сууц ихээр баригдаж байгаатай холбогдуулан барилгын материалын хэрэгцээ, түүнчлэн элс хайрганы хэрэгцээ жилээс жилд өссөн нэмэгдэж байна.

Энэ бүтээн байгуулалтын ажилд өөрийн хувь нэмрээ оруулах зорилоор “Дархан молор-эрдэнэ” ХХК нь MV-001824 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн дагуу түгээмэл тархацтай ашигт малтмал болох элс олборлох үйл ажиллагааг явуулж байна.

“Ашигт малтмалын тухай” хуулиар хүлээсэн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн дагуу нөхөн сэргээлтийн ажлыг жил бүрийн ажлын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байна.

2023 онд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 10 гаруй ажилтан, 1 ачигч, 1 эксковатор, HOWO маркын автомашинаар 0.6 га талбайд дээр дурьдсан хэлбэрээр гүйцэтгэхээр төлөвлөж байна. Ачигч болон бульдозер ашиглан эвдэрсэн талбайг түрж хэвгийжүүлэх, хэлбэржүүлэх ажлыг, нөхөн дүүргэлтийг автомашинаар зөөж тээвэрлэлээ.

Нөхөн сэргээлтийг өөрийн нөөц бололцоо машин техник, хүн хүчид тулгуурлан ашиглалт, олборлолтын явцад үүссэн дотоод болон гадаад овоолго, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарсан хаягдал чулуулгыг ашиглан нөхөн дүүргэлт хийх, тэгшлэх, шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлтэд бэлтгэх, налуулах, хэвгийжүүлэх гэх мэт хэлбэрээр хийж хүрээлэн байгаа орчин, хүн малд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр засаж тохижууллаа.

Хөрс хуулалттай холбоотой үүссэн овон товон гадаргууг ерөнхийд нь сийрүүлэн тэгшлэх, налуу гадаргууг орчных нь гадаргуутай ойртуулан хэлбэршүүлэх, ажиллагаанууд хийгдэж, дараа нь нарийвчлан хэлбэржүүлж, өнгөлөн тэгшлэх ажиллагааг гүйцэтгэлээ.

Нөхөн сэргээлтийн стандартад заасны дагуу хэлбэржүүлэхдээ орчны газрын тогтоцыг харгалзан ойролцоох газрын хэлбэрт аль болох ойртуулан ажиллана.

Нөхөн сэргээлтийг:

- Ашиглагдсан орон зайг нөхөн дүүргэх;
- Ашиглагдсан орон зай, ухшийг хэвгийжүүлэх, хэлбэршүүлэх;
- Эвдэрсэн газрыг болон овоолгыг тэгшлэх, гадаргууг нь хэлбэржүүлэн тэгшлэх;
- Овоолгын хажууг хэвгийжүүлэн дэвсэгжүүлэх;
- Тэгшилсэн талбайг нягтаршуулах зэрэг хэлбэрээр хийлээ.

Ачигч ашиглан эвдэрсэн талбайг түрж хэвгийжүүлэх, хэлбэржүүлэх ажлыг, нөхөн дүүргэлтийг автомашинаар зөөж тээвэрлэнэ.

ЗУРГАА. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоход уурхайн явцад газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, газрын гүний усан орчин зэрэгт сөргөөр нөлөөлөх нь тогтоогдлоо. Иймд төслийг хэрэгжүүлэх үед үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний талаар доорх зөвлөмжийг өгч байна.

6.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Төслийн агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахын тулд дараах арга хэмжээг авна. Үүнд:

Тээвэрлэлтээс үүсэх тоосжилтыг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

- 1) Уурхайн олборлолтын үйл ажиллагаанд агаарт тодорхой хэмжээний тоос үүсдэг бөгөөд ашиглалтын талбай нь хүн амын суурьшилт, салхиар дамжин хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлж уурхайн талбайд усалгаа хийх
- 2) Мөн түүнчлэн сурфактант уусмал, давс, нефтийн эмульс, нийлэг материал, цавуурхаг материалуудыг ашиглаж болно.

- 3) Тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийн кабинд үйлчилгээ хийх, машин тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тогтмол хийх зэрэг болно.

Овоолго болон задгай талбайн тоосжилтыг бууруулах зөвлөмж

Ил уурхайн бүсэд задгай талбай болон овоолгуудыг бий болгодог. Салхины хурд 5.7 м/с хүрэхэд хөрс шорооны жижиг диаметртэй (0.1 мм) эгэл хэсгүүд дэгдэж эхэлдэг [Сhepil 1958]. Салхины элэгдэлийг бууруулах хэд хэдэн хүчин зүйл байдаг. Үүнд:

- Хөрсний бүтцэд салхины элэгдэлд тэсвэртэй харьцангуй том ширхэглэлтэй бүрэлдэхүүнүүд байх;
- Шимт хөрс болон, хөрсний овоолгын гадаргууг нягтруулах, гадаргууг тэгш бус болгох, чийгшүүлж байх; эсвэл зүлэгжүүлэх зэргээр тоосжилт үүсгэхгүй арга хэмжээг авах
- Газрын гадарга орчмын салхины хурдыг бууруулах эсвэл хязгаарлах

6.2 Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахдаа дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Төслийн үйл ажиллагааны явцад үүссэн газрын гадаргын эвдрэлд өртсөн хэсгүүдэд ажлын явцад төрх байдлын сайжруулалт хийж, ухмал нүх овоолгыг тэгшилж байх.
- Суурингийн талбайд хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд болон тухайн орчиндоо сөрөг нөлөөллийг бий болгох газар ашиглалтыг төлөвлөхгүй байх.
- Төслийн явцад хийгдэх зайлшгүй шаардлагатай газар шорооны ажил, агуулах, үйлчилгээний хэсэг байгуулах зэрэг ажил нь барилга байгууламжийн дэвсгэрээс бусад талбайн газрын гадаргыг өөрчлөлтөнд оруулдаг ч орчны тохижилт, ногоон байгууламжийг зохистой байршуулж асуудлыг шийдвэрлэх боломжтой.
- Төслийн талбайн орчимд ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг зайлуулахдаа зориулалтын хогийн цэг байгуулан асгаж байх шаардлагатай.
- Газрын хэвлийг төслийн хүрээнээс гадна аль болох бага хөндөх, ажил гүйцэтгэхэд ашиглах талбайг нөхөн сэргээх
- Ногоон байгууламж бий болгох

6.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Элс олборлох уурхайн төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Төслийн явцад хөрсийг ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдал болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байх
- Уурхайгаас гарах шороог төслийн дагуу овоолгын талбайд зөв байрлуулан асгаж, дагтаршуулах, хур тунадас, салхины нөлөөгөөр үүсэх хагарал, хотойлт зэргийн шалтгааныг судалж түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байх шаардлагатай
- Авто засварын газрын талбайг тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж, цардаж өнгөлөх, тэмдэгжүүлэх
- Олборлолт дууссаны дараа техникийн нөхөн сэргээлт хийх

- Техникийн нөхөн сэргээлт хийсэн газрыг өтөг бууцаар бордож, олон наст ургамлын үр цацах, мод бут суулгах зэргээр биологийн нөхөн сэргээлт хийх
- Уурхайн олборлолт, барилга байгууламж байгуулах явцад эвдэрсэн хөрсийг засч тэгшлэх, нөхөн сэргээх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх
- Хөрс хадгалах зориулалттай талбайг сонгохдоо салхи, усны нөлөөгөөр хөрс элэгдэлд орох нөхцлийг хамгийн бага байхаар төлөвлөх
- Шимт хөрсийг хамгаалахын тулд овоолгын өнгөн хэсгийг сэргээх, үүний тулд овоолгын гадаргуугийн хөрсөнд усалгаа хийх, тохиромжит ургамлын үр цацах, гадаргуугийн бүрхэвч бий болгох, хажуу бэлийг хамгаалах зорилгоор геоматериалаар хучих арга хэмжээ авах

6.4 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- Гол, мөрний байгалийн үндсэн голдирлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэргүйгээр өөрчлөхгүй байх ёстой.
- Газрын доорх ус буюу ундны усны нөөцийг бохирдуулагч эх үүсвэр нь хөрсний бохирдол юм. Хөрсөн дээр асгарсан, гоожсон шатах, тослох материал түүний үе давхаргуудад шүүрэн нэвчиж газрын доорх усыг бохирдуулна. Нөгөө талаар бороо хурын ус чийг, хөрсөнд бий болсон дээрх бохирдлуудыг цааш дамжихад ихээхэн нөлөөлөлтэй байдаг тул нэн түрүүн хөрсийг шатах, тослох материалаар бохирдохоос хамгаалах, бохирдсон нөхцөлд нэн даруй арга хэмжээ авч байх шаардлагатай.
- Өөрийн ашиглалтын талбай дахь болон эргэн тойрны хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж, нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллана.
- Ажилчид болон төслийн талбай түүний нөлөөллийн бүсэд байх талбай дахь ард иргэдийн унд ахуйн хэрэгцээний усны чанар нь стандарт, норм, нормативд нийцэх эсэхэд байнга хяналт тавьж ажиллана.

6.5 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Төслийн явцад ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах замаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Жил бүр ургамлын мониторинг судалгааг явуулах
- Ашиглалтын талбайн ургамал бүрхэвчийг хамгаалах үүднээс олон салаа зам гаргахгүй байх, маршрутын зам гаргах
- Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хогийн нэгдсэн цэг байгуулах, хогийг орчиндоо тархахааргүй байх талаар арга хэмжээ авах
- Ашиглалтын талбайн 10 хувьд ногоон байгууламж бий болгох

6.6 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах

- Холбогдох хуулийг нийт ажиллагсадад танилцуулан, нутгийн унаган болоод нүүдлийн ан амьтдыг хамгаалах, амьтны байршил хөдөлгөөнд аль болох нөлөөлөхгүй байх, уулын малгалт овоолгыг ан амьтанд аюулгүй байхаар байрлуулах шаардлагатай.
- Төслийн орчимд элдэв халдварт өвчин тараах хэрээ, жунгаа гэх мэт шувуудыг хэт олшрохоос урьдчилан сэргийлж ил задгай хог хаягдал, хоол хүнсний үлдэгдэл хаяхгүй байх.
- Төслийн талбайд мал, амьтан орж, машин механизмд дайруулж хорогдохоос сэргийлж, байнгын хараа хяналт тавих, хашаа, хайс барих

- Уурхайн талбай, түүний орчинд хогийн цэг дээр амьтан тэжээл хайж ирэх, орогнох, үүрлэх нөхцөл үүсгэхгүй байх, ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдлаас мал, амьтан хордох явдлаас сэргийлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.
- Хууль бус ан, агнуур хийхгүй байх

6.7 Нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд:

- Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах
- Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулах,
- Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд байнгын хяналт тавих
- Ажилчдын ажлын байрны аюулгүй орчныг бүрдүүлэх, хүнд нөхцөлд ажиллагсдад нэмэгдэл цалин, урамшуулал олгох
- Ажилчдын цалинг цаг тухай бүрт нь олгох зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Нутгийн оршин суугчид болон ажиллагсдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Ажил эхлэхийн өмнө ажилчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, гэнэтийн осол гамшгаас урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, хөдөлмөр, аюулгүй ажиллагааны самбар ажиллуулах, ажлын хувцсаар хангаж, галын хортой ажиллах заавар өгч, эмнэлэгийн анхны тусламж үзүүлэх буланг байгуулах зэрэг ажлуудыг зохион байгуулсан байх ёстой.
- Уурхайн ажиллагсдад тусгай зориулалт бүхий амны хаалт, хувцас хэрэгсэл олгох.
- Ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт оруулж, уурхайн ажилчдын өвчлөлтийн талаар судалгаа дүгнэлт гаргах
- Орон сууц, хоолны газар, ажлын байрны эрүүл ахуйд хяналт тавьж ажиллах
- Дуу чимээ ихтэй нөхцөлд ажиллах ажиллагсдад зориулалтын чихний бөглөө олгох
- Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх багаж хэрэгслийг ажлын байруудад зохих шаардлагын дагуу бэлтгэж байрлуулах
- Уурхайн ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, аврах багийн хүрээнд сургалтанд хамруулах
- Нутгийн оршин суугчид болон ажиллагсдын эрүүл аюулгүй байдлыг хангах үүднээс бохирын худагтсар бүр хуваарийн дагуу ариутгал, халдваргүйжүүлэлт хийх.
